ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2025/061/НА-СТА-ТШЗ**

## ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Д.Бямбасүрэн
Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/76

танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.ЖАМЪЯНСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага тайлант онд хөрөнгийн тооллогыг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/88 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй тооллогыг хийсэн ч, 8,110,789.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 198,003.4 мянган төгрөгийн бараа материалын тооцоог нягтлан бодогч бодоогүй, 146,400.0 мянган төгрөгийн өмнөх оны хөрөнгө оруулалтын ажлын авлагыг барагдуулаагүй, НДШ-д 4,909.1 мянган төгрөг, ХАОАТ-т 5,372.1 мянган төгрөг, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, бусад байгууллагад 1,262.7 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх” энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

41250?07?

20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн аймгийн Баян-Өнжүүл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

**Бусад асуудал**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 30 арга хэмжээ төлөвлөн, гүйцэтгэлээр 86,0%-ийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **322,329,840.23** | **344,403,365.79** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,000.00 | 00.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 1,000.00 | 00.00 |
| 31110 | Төгрөг | 1,000.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | **147,921,466.44** | **146,400,000.00** |
| **335** | **Бусад авлага** | **147,921,466.44** | **146,400,000.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 147,921,466.44 | 146,400,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **174,407,373.79** | **198,003,365.79** |
| **354** | **Хангамжийн материал** | **165,557,373.79** | **189,153,365.79** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,749,260.00 | 2,749,260.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 89,417,248.48 | 93,513,248.48 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 73,390,865.31 | 92,890,857.31 |
| 35600 | Мал амьтад | 8,850,000.00 | 8,850,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,817,968,666.74** | **3,572,255,526.96** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,817,968,666.74** | **3,572,255,526.96** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,731,505,166.75** | **1,891,169,893.96** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,673,564,699.62 | 1,673,564,699.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -479,472,636.64 | -555,439,150.82 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 312,200,020.00 | 312,200,020.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -141,899,270.31 | -189,125,247.88 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 136,287,699.20 | 138,707,699.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -63,219,074.53 | -92,434,721.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 148,233,580.17 | 149,713,480.17 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -41,705,143.37 | -59,771,855.77 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 396,699,116.00 | 758,095,078.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -209,183,823.39 | -244,340,107.29 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **86,463,499.99** | **1,681,085,633.00** |
| 39301 | Програм хангамж | 1,740,000.00 | 8,740,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,392,500.01 | -1,740,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 86,116,000.00 | 1,674,085,633.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,140,298,506.97** | **3,916,658,892.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **111,676,600.00** | **11,543,911.52** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **111,676,600.00** | **11,543,911.52** |
| **413** | **Өглөг** | **111,676,600.00** | **11,543,911.52** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 10,281,176.21 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 700,535.31 |
| **4136** | **Бусад өглөг** | **111,676,600.00** | **562,200.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 111,676,600.00 | 562,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,028,621,906.97** | **3,905,114,981.23** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,028,621,906.97 | 3,905,114,981.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 851,574,968.37 | 851,574,968.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 851,574,968.37 | 851,574,968.37 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **765,170,602.30** | **2,641,663,676.56** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 765,170,602.30 | 765,170,602.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,876,493,074.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 411,876,336.30 | 411,876,336.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,140,298,506.97** | **3,916,658,892.75** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **989,722,618.96** | **3,160,386,919.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **176,738,199.98** | **1,969,706,387.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 176,738,199.98 | 1,969,706,387.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 176,738,199.98 | 1,969,706,387.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 315,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 1,969,391,387.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **812,984,418.98** | **1,190,680,532.48** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **215,676,619.00** | **252,427,132.48** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 215,676,619.00 | 252,427,132.48 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **597,306,799.98** | **938,253,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 597,306,799.98 | 938,253,400.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 1,000.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **844,018,471.55** | **1,283,893,845.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **648,789,969.78** | **1,151,893,845.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **647,789,969.78** | **1,077,102,908.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **312,776,753.57** | **571,668,492.79** |
| 210101 | Үндсэн цалин | 224,137,070.02 | 341,487,111.61 |
| 210102 | Нэмэгдэл | 63,447,585.97 | 206,104,562.21 |
| 210104 | Урамшуулал | 25,192,097.58 | 24,076,818.97 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,246,125.62** | **70,955,474.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,177,766.04 | 48,294,566.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,104,154.84 | 5,681,753.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,386,964.01 | 2,990,899.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 602,130.94 | 2,797,640.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,975,109.79 | 11,190,614.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,260,085.71** | **49,133,743.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,867,612.01 | 10,436,130.91 |
| 210302 | Түлш, халаалт | 38,392,473.70 | 38,697,612.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **32,913,800.00** | **57,912,843.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,203,000.00 | 3,185,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,341,100.00 | 51,727,743.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,799,500.00 | 3,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 453,500.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 76,700.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,040,000.00 | 00.00 |
| **2105** | **Норматив зардал** | **490,000.00** | **1,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 490,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,661,200.00** | **10,211,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,661,200.00 | 10,211,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,311,800.00** | **7,258,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,311,800.00 | 7,258,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,760,834.00** | **12,349,224.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 403,200.00 | 9,786,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 1,612,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 341,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 600,684.00 | 607,474.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 152,150.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 1,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **205,369,370.88** | **296,614,129.78** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,121,201.87 | 90,635,495.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 175,248,169.01 | 205,978,634.78 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,000,000.00** | **74,790,937.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **27,495,622.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 5,782,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 13,083,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 7,260,222.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,370,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **47,295,315.05** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 47,295,315.05 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **195,228,501.77** | **132,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **130,140,250.00** | **132,000,000.00** |
| 221001 | Их засвар | 111,676,600.00 | 00.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 18,463,650.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 132,000,000.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 65,088,251.77 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **145,704,147.41** | **1,876,493,074.26** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-78,841,523.00** | **00.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | -78,841,523.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 78,841,523.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **224,545,670.41** | **1,876,493,074.26** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **812,984,418.98** | **1,190,995,532.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **315,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 315,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 315,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 315,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **812,984,418.98** | **1,190,680,532.48** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **215,676,619.00** | **252,427,132.48** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 215,676,619.00 | 252,427,132.48 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **597,307,799.98** | **938,253,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 597,306,799.98 | 938,253,400.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | 1,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **719,633,818.98** | **1,024,294,332.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **719,633,818.98** | **1,024,294,332.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **653,545,567.21** | **948,677,395.43** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **312,776,753.57** | **556,292,185.97** |
| 210101 | Үндсэн цалин | 224,137,070.02 | 338,282,002.32 |
| 210102 | Нэмэгдэл | 63,447,585.97 | 201,845,167.86 |
| 210104 | Урамшуулал | 25,192,097.58 | 16,165,015.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,848,214.53** | **70,955,474.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,268,853.89 | 48,294,566.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,200,128.67 | 5,681,753.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,590,848.82 | 2,990,899.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 621,325.71 | 2,797,640.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,167,057.44 | 11,190,614.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **47,286,891.11** | **48,720,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,868,017.41 | 9,188,689.58 |
| 210302 | Түлш, халаалт | 38,392,473.70 | 39,531,310.42 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 26,400.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,546,600.00** | **40,707,445.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,899,500.00 | 2,677,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,041,100.00 | 32,629,745.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,806,000.00 | 3,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 600,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,200,000.00 | 2,400,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **473,500.00** | **1,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 473,500.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,407,200.00** | **10,080,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 160,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,407,200.00 | 9,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,311,800.00** | **7,258,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,311,800.00 | 7,258,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,818,061.00** | **19,457,449.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,460,427.00 | 10,899,125.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 341,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 600,684.00 | 445,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 152,150.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 7,000,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 1,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **209,076,547.00** | **194,206,840.57** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 209,076,547.00 | 194,206,840.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66,088,251.77** | **75,616,937.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **28,321,622.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,608,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 13,083,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 7,260,222.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,370,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 65,088,251.77 | 47,295,315.05 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 65,088,251.77 | 47,295,315.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **93,350,600.00** | **166,701,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 93,349,600.00 | 166,702,200.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **93,349,600.00** | **166,702,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 93,349,600.00 | 166,702,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 44,464,530.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 146,032,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 48,885,070.00 | 20,670,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-93,349,600.00** | **-166,702,200.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 1,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,000.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 851,574,968.37 | 411,892,248.30 | 294,126,591.76 | 00.00 | 1,557,593,808.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **851,574,968.37** | **411,892,248.30** | **294,126,591.76** | **00.00** | **1,557,593,808.43** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 41,418,240.10 | 00.00 | 41,418,240.10 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **851,574,968.37** | **411,876,336.30** | **765,170,602.30** | **00.00** | **2,028,621,906.97** |
| D01 | **2024 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл** | **851,574,968.37** | **411,876,336.30** | **765,170,602.30** | **00.00** | **2,028,621,906.97** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | **00.00** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **851,574,968.37** | **411,876,336.30** | **765,170,602.30** | **00.00** | **2,028,621,906.97** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,876,493,074.26 | 00.00 | 1,876,493,074.26 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **851,574,968.37** | **411,876,336.30** | **2,641,663,676.56** | **00.00** | **3,905,114,981.23** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **937,964,600.00** | **898,756,689.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **776,932,400.00** | **737,724,489.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **755,741,000.00** | **716,663,089.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **529,157,800.00** | **502,494,214.28** |
| 210101 | Үндсэн цалин | 340,284,300.00 | 335,947,660.54 |
| 210102 | Нэмэгдэл | 170,733,100.00 | 150,381,537.95 |
| 210104 | Урамшуулал | 18,140,400.00 | 16,165,015.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **66,144,800.00** | **63,864,848.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,978,400.00 | 43,462,228.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,291,600.00 | 5,113,232.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,645,800.00 | 2,706,605.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,645,800.00 | 2,516,516.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,583,200.00 | 10,066,265.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,720,000.00** | **48,720,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,400,000.00 | 9,188,689.58 |
| 210302 | Түлш, халаалт | 40,320,000.00 | 39,531,310.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,777,700.00** | **24,977,300.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,677,700.00 | 2,677,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,899,600.00 | 16,899,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,200,400.00 | 2,400,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,500,000.00** | **12,500,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 2,580,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 9,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,686,000.00** | **6,578,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,686,000.00 | 6,578,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **21,604,800.00** | **21,304,598.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,750,000.00 | 12,747,274.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 341,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 700,000.00 | 445,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **42,149,900.00** | **35,224,128.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,149,900.00 | 35,224,128.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,191,400.00** | **21,061,400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **21,191,400.00** | **21,061,400.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,608,000.00 | 6,608,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,083,400.00 | 13,083,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,370,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **161,032,200.00** | **161,032,200.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 161,032,200.00 | 161,032,200.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **937,964,600.00** | **938,568,400.00** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **776,932,400.00** | **938,253,400.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 776,932,400.00 | 938,253,400.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **161,032,200.00** | **315,000.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 315,000.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 161,032,200.00 | 0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 1,000.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **45** | **45** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **22** | **22** |
| 620001 | Удирдах ажилтан | 6 | 6 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 12 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22** | **22** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 4 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4 | 4 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 5 | 5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **197,346,865.68** | **244,944,528.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **197,346,865.68** | **244,944,528.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **197,346,865.68** | **237,686,306.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **15,896,884.98** | **53,797,971.69** |
| 210101 | Үндсэн цалин | 15,896,884.98 | 2,334,341.78 |
| 210102 | Нэмэгдэл | - | 51,463,629.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,849,980.70** | **7,090,626.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,239,314.96 | 4,832,338.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 137,830.00 | 568,521.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 215,809.76 | 284,294.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 27,566.00 | 281,124.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 229,459.98 | 1,124,349.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **15,730,145.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 15,730,145.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **680,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 680,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **1,402,851.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,402,851.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **179,600,000.00** | **158,982,712.57** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 179,600,000.00 | 158,982,712.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **7,260,222.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **7,260,222.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 7,260,222.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **7,482,604.22** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,482,604.22 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **215,676,619.00** | **252,427,132.48** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **215,676,619.00** | **252,427,132.48** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 215,676,619.00 | 252,427,132.48 |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 390,565.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа.

**Залруулсан алдаа**:

- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 100,000.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний журналд тайлагнаагүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьсан 286,491.0 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээний өргөтгөл бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.
- Санхүүгийн байдлын тайланд өр төлбөр данс 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө 4,013.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 4,875,929.6 мянган төгрөгийн зөрчлөөс 4717,985.7 мянган төгрөгийн материаллаг, 157,943.9 мянган төгрөгийн материаллаг бус зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,709,840.9 мянган төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,875,929.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 2,879.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,715,106.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 3 зөвлөмж хүргүүллээ.

**Залруулаагүй алдаа:**

#### 3.1 Төлбөрийн акт

1.Ахмадын зөвлөлийн даргын урамшуулалд 1,629.1 мянган төгрөг илүү олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2.Шинэ жил тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 1,250.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

**3.2 Албан шаардлага**

3.Тус байгууллага тайлант онд хөрөнгийн тооллогыг Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/88 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй хийсэн ч, 4,715,106.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооцоог нягтлан бодогч бодоогүй зөрчил илэрлээ. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-д "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

**3.3 Зөвлөмж**

5. Авлага данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Өмнөх оны 146,400.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын авлагыг барагдуулж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх" гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Цаашид авлагыг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

6. Өр, төлбөр данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тайланд онд НДШ-д 4,909.1 мянган төгрөг, ХАОАТ-т 5,372.1 мянган төгрөг, бусад байгууллагад 1,262.5 мянган төгрөг нийт 11,543.9 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн

заалтыг болон санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Цаашид өр төлбөрийг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

7. Шилэн данстай холбоотой асуудал

Тайлант онд тус Засаг даргын тамгын газар шилэн дансны 159 мэдээлэл байршуулахаас 141 мэдээлэл хугацаанд нь, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 18 мэдээллийг хугацаанд байршуулаагүй, хэрэгжилт 88,3%-тай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлагналтай холбоотой алдаа | 5 | 390,565.2 | 3 | 4,074.2 | 2 | 386,491.0 | 3 | 390,565.2 | | | | |
| **Дүн** | **5** | **390,565.2** | **3** | **4,074.2** | **2** | **386,491.0** | **3** | **390,565.2** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ахмад зөвлөлийн урамшуулал илүү олгосон | 1 | 1,629.1 | 1 | 1,629.1 | | | | |
| Шинэ жил тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд мөнгө зарцуулсан. | 1 | 1,250.0 | 1 | 1,250.0 | | | | |
| Үндсэн хөрөнгө, бараа материалын тооцоо нягтлан бодогч бодоогүй | 1 | 4,715,106.9 | | | 1 | 4,715,106.6 | | |
| Өмнөх оны авлагыг барагдуулж ажиллаагүй. | 1 | 146,400.0 | | | | | 1 | 146,400.0 |
| Тайланд онд шинээр өр төлбөр үүссэн | 1 | 11,543.9 | | | | | 1 | 11,543.9 |
| Дүн | **5** | **4,875,929.6** | **2** | **2,879.1** | **1** | **4,715,106.6** | **2** | **157,943.9** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд 18 мэдээлэл хуулийн хугацаанд байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | **0** | | | | | **1** | **0** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn